



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 01 өдөр

Дугаар А/593

Зуунмод

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Хүүхдийн автобус” төсөл, арга хэмжээний тус бүр 70,000,000 (далан сая) төгрөгийн үнэ бүхий хүүхдийн автобус нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах эрхийг Батсүмбэр, Баянхангай, Баянчандмань, Эрдэнэсант, Эрдэнэ сумын Засаг дарга нарт шилжүүлсүгэй.

2. Сонгон шалгаруулалтыг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, сонгон шалгаруулалтын баримт бичгийг боловсруулан хүргүүлж, хяналт тавин ажиллахыг аймгийн Худалдан авах ажиллагааны газар (Б.Ганхуяг), Төв аймаг дахь Автотээврийн төв (Н.Аасүрэн) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

4124011286